

## САЙДЫН ТУШААЛ

## Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Ганбат/, Хууль, эрх зүйн газар /З.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж дагаж мөрдөнө.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 255 дугаар тушаал, 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 132 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ЖАВХЛАН

## ЦАХИМ СИСТЕМЭЭР ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам (цаашид “журам” гэх)-ын зорилго нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (цаашид “цахим систем” гэх)-ээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, хэрэгжилтийг хангах, гомдол шийдвэрлэлтийг мэдээлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Цахим систем нь [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягтай байх ба худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “мэргэжлийн байгууллага” гэх) цахим системийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

1.3.Захиалагч, аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогч болон холбогдох бусад этгээд цахим системийг хэрэглэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн байгууллагаас гаргасан журам, аргачлал, зааварчилгааг дагаж мөрдөнө.

### Хоёр.Худалдан авах ажиллагаа зохион байгуулах

2.1.Захиалагч худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулна.

2.2.Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу цахим системд бүртгэгдсэн захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг дараах дарааллын дагуу зохион байгуулна:

2.2.1.үнэлгээний хороог цахим систем дэх худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны мэдээллийн санд бүртгэлтэй этгээдээс сонгож цахим системээр байгуулах;

2.2.2.үнэлгээний хороо байгуулсан шийдвэр, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг цахим системд бүртгэх;

2.2.3.үнэлгээний хороо тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, захиалагчаар батлуулсны дараа тендер шалгаруулалтын зарлал, урилга, тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим системд нийтлэх;

2.2.4.хуульд заасан үндэслэлээр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар сонирхогч этгээдээс тодруулга авах хүсэлт гаргасан бол тодруулгыг гарсан өдөр нь хүсэлт гаргасан сонирхогч этгээдийн нэрийг

дурдалгүйгээр албан бичгээр цахим систем дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлж, шаардлагатай бол тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах;

2.2.5.хуулийн 23.1-д зааснаар тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хугацаанд тендерийг цахим системээр нээх;

2.2.6.тендер шалгаруулалттай холбоотой гомдол захиалагчид ирсэн бол гомдлын агуулгыг цахим системд нийтлэх;

2.2.7.үнэлгээний хороо хууль, холбогдох журам, зааврын дагуу тендерийг хянан үзэж, үнэлэх, захиалагчид зөвлөмж хүргүүлэх;

2.2.8.үнэлгээний хороо захиалагчийн шийдвэр, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд бүрэн нийтэлж, шалгарсан оролцогчийн тендерийн нууцлаагүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулгыг гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын таван өдрийн хугацаанд цахим системээр бусад оролцогчид ил болгох;

2.2.9.худалдан авах гэрээг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилтийг тухай бүр цахим системд хөтлөх.

2.3.Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу цахим системд бүртгэгдсэн аж ахуй эрхлэгч цахим системээр зохион байгуулж буй тендер шалгаруулалтад дараах байдлаар оролцоно:

2.3.1.тендер шалгаруулалтад түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй оролцох бол холбогдох гэрээг цахим системээр байгуулсан байх;

2.3.2.хуульд заасан үндэслэлээр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлтийг тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гаргах;

2.3.3.тендерийн баталгаа шаардсан нөхцөлд хуулийн 22.7-д заасны дагуу тендерийн баталгааг цахим системээр дамжуулан хүргүүлэх;

2.3.4.Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу цахим системд бүртгэгдсэн аж ахуй эрхлэгчийн чадавх, туршлагыг нотлох мэдээлэл, баримт бичгээс шаардлагатайг сонгож, тендерийн хамт илгээх;

2.3.5.хуулийн 15.2-т болон энэ журмын 2.3.4-т заасанд хамаарахгүй оролцогчийн ерөнхий шаардлага, чадавх, туршлагыг нотлох баримтыг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим хэлбэрээр “PDF” форматаар гаргацтай, тод хөрвүүлж тендер илгээх;

2.3.6.тендерийн үнэ, тендерийн хүчинтэй байх хугацаа, санал болгосон үнийн хөнгөлөлт болон холбогдох бусад мэдээллийг цахим системийн холбогдох талбарт бүрэн оруулж, мэргэжлийн байгууллагын гаргасан зааварчилгааны дагуу тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх;

2.3.7.цахим системд тендер илгээхэд хуулийн этгээд бол түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн, иргэн бол тухайн иргэний тоон гарын үсгээр баталгаажуулах;

2.3.8.цахим системээр тендер илгээхэд төлөх үйлчилгээний хураамжийг төлөх;

2.3.9.шаардлагатай гэж үзвэл тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендертээ нэмэлт, өөрчлөлт оруулах.

2.4.Тендер шалгаруулалтын зарлал, урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.

2.5.Захиалагч цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараах журмаар ирүүлсэн тендер шалгаруулалт зарласнаас хойших мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгоно:

2.5.1.татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт зэрэг бодит цагийн горимоор дамжуулдаг мэдээлэл;

2.5.2.Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөртэй эсэх тодорхойлолт. Уг тодорхойлолтыг тендер оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим системээр дамжуулан авч цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбосон байх;

2.5.3.хуульд заасан эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл (энгийн болон тусгай)-ийн мэдээлэл, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, дээд боловсролын дипломын мэдээлэл, санхүүгийн тайлан зэрэг бодит цагийн горимоор дамжуулдаг, өдөр тутам өөрчлөгддөггүй мэдээлэл.

2.6.Энэ журмын 2.5 дахь заалт хуулийн 4.1.6-д заасан гадаадын этгээдийн ирүүлсэн тендерт хамаарахгүй.

2.7.Захиалагч энэ журмын 2.2.4-т зааснаас бусад үндэслэлээр тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулах бол энэ тухай цахим систем дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлж, тендер шалгаруулалтын баримт бичигт холбогдох өөрчлөлтийг тусгана.

2.8.Захиалагчийн цахим системд оруулсан мэдэгдлийн талаар зурвасыг цахим системд бүртгүүлсэн аж ахуй эрхлэгчийн бүртгэлтэй цахим шуудангийн хаягаар илгээж мэдэгдэх ба аж ахуй эрхлэгч тухайн цахим шууданг ашиглаж байгаа эсэхээс үл хамааран хүлээн авсанд тооцно.

2.9.Захиалагчийн шийдвэр, тендер шалгаруулалтын үр дүнг энэ журмын 2.2.8-д заасны дагуу цахим системээр оролцогчид нэгэн зэрэг мэдэгдсэн өдрөөс эхлэн хуулийн 30.1-д заасан гэрээг байгуулах хугацааг тоолно.

2.10.Захиалагч болон аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогчоос ажлын цаг дууссаны дараа, эсхүл амралтын өдөр цахим системд оруулсан баримт бичгийг холбогдох этгээд дараагийн ажлын өдөр хүлээн авсанд тооцно.

2.11.Оролцогч энэ журмын 2.3.1-д зааснаар холбогдох этгээдтэй гэрээ байгуулаагүй бол түншлэл, эсхүл туслан гүйцэтгүүлэх гэрээ бүхий тендер ирүүлсэн оролцогч гэж үзэхгүй.

2.12.Оролцогчоос ирүүлсэн тендер энэ журмын 2.3.5-д заасан шаардлага хангаагүй бол тухайн баримт бичгийг үнэлгээнд харгалзан үзэхгүй.

2.13.Оролцогчоос ирүүлсэн тендер энэ журмын 2.3.6-д заасны дагуу цахим системийн холбогдох талбарт оруулсан мэдээлэлтэй зөрвөл цахим системийн мэдээллийг баримтална.

2.14.Тендерийг энэ журмын 2.3.7-д заасан этгээдээс өөр этгээдийн тоон гарын үсгээр баталгаажуулан цахим системд ирүүлснийг тендерт оролцсон гэж тооцно.

#### Гурав.Тендер илгээхэд төлөх үйлчилгээний хураамж

3.1.Цахим тендер шалгаруулалтад цахим системээр тендер илгээх үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

3.2.Тендер илгээх үйлчилгээний хураамж 50,000.0 (тавин мянга) төгрөг байна.

3.3.Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн байгууллагатай байгуулсан гэрээнд үндэслэн аж ахуй эрхлэгчийг тендер илгээх үйлчилгээний хураамж төлөх боломжоор хангана.

3.4.Хуулийн 49.4.7-д заасныг цахим системийн үйлчилгээний нөхцөлд тусгана.

3.5.Оролцогч илгээсэн тендерээ буцаасан, эсхүл тендер шалгаруулалтад оролцоогүй нь тендер илгээх үйлчилгээний хураамжийг буцаан олгох үндэслэл болохгүй.

#### Дөрөв.Тендерийн болон гүйцэтгэлийн баталгаа

4.1.Тендерийн баталгаа шаардсан тендер шалгаруулалтад тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерийн баталгааг, гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэлийн баталгааг хуульд заасан хэмжээгээр баталгаа гаргах эрх бүхий этгээдээс цахим системээр гаргуулсан байна.

4.2.Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ын 2.5-д заасан хамтын удирдлагын бүтэц нь даатгагчийн гаргаж буй баталгааг хууль болон журамд заасан шаардлага хангаж байгаа эсэхийг хянан баталгаажуулснаар цахим системээр илгээнэ.

4.3.Хуульд заасан баталгаа гаргах эрх бүхий этгээд нь цахим системд мэдээлэл дамжуулах нөхцөл, шаардлагыг хангуулж, мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр цахим системээр баталгаа гаргах эрхтэй байна.

4.4.Цахим системээр баталгаа гаргагч нь тендерийн болон гүйцэтгэлийн баталгааны маягтад заасан мэдээллийг цахим системд илгээнэ.

4.5.Гадаадын этгээд гадаад улсын банкнаас баталгаа гаргуулахад баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдээр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан кореспондент банкиг заасан байна.

4.6.Энэ журмын 4.5-д заасны дагуу гадаад улсын банкнаас ирүүлсэн баталгааг цахим системээр баталгаа гаргагч энэ журмын 4.4-т зааснаар цахим системд илгээнэ.

4.7.Энэ журмын 4.4-т заасны дагуу илгээсэн баталгааг хүчингүй болгох хүсэлтийг оролцогч цахим системээр дамжуулан гаргана. Захиалагч хуульд заасны дагуу баталгааг цахим системээр хүчингүй болгоно.

4.8. Энэ журмын 4.1, 4.5-д зааснаар тендерийн баталгаа ирүүлээгүй бол хуулийн 23.3-т заасан нөхцөл үүссэн гэж үзнэ.

#### Тав.Мэргэжлийн байгууллагын эрх, үүрэг

5.1.Мэргэжлийн байгууллага Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д зааснаар цахим системийн мэдээлэл хариуцагч байх ба тус хуульд заасан үүргийг хэрэгжүүлнэ.

5.2.Мэргэжлийн байгууллага цахим системтэй холбоотой дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.2.1.цахим систем болон түүний бүрэлдэхүүн хэсгийн портал хуудсыг хөтлөх, бүртгэлийн тогтолцоог ханган ажиллах, цахим системийн хэвийн үйл ажиллагааг хариуцах;

5.2.2.цахим системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагаа, сургалт, сурталчилгаа, нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллах;

5.2.3.баталгаа гаргагч, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч, бусад төрийн байгууллага, тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэгч байгууллага болон бусад шаардлагатай байгууллагатай гэрээ байгуулж ажиллах;

5.2.4.энэ журмын 5.2.3-т заасны дагуу байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянаж, хангаж ажиллах;

5.2.5.цахим системийн тухай аливаа тодруулга, тайлбар, мэдээллийг захиалагч, аж ахуй эрхлэгч болон бусад этгээдэд өгөх;

5.2.6.цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүнд оролцох тухай сургалтыг тогтмол зохион байгуулах;

5.2.7.тендер шалгаруулалттай холбоотойгоор цахим системд захиалагчаас оруулж буй мэдэгдэл, нэмэлт мэдээлэл, тодруулга, тендер шалгаруулалтын баримт бичгийн нэмэлт, өөрчлөлт, гомдол хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдээллийг оролцогчид цахим шуудан, эсхүл гар утасны зурвас

болон харилцаа холбооны бусад хэлбэрээр дамжуулан хүргэх техникийн шийдлийг бий болгон ажиллах;

5.2.8.тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх, лавлагаа тодорхойлолт зэрэг нийтийн мэдээлэл солилцохоор гэрээ байгуулсан байгууллагуудыг цахим системд нэвтэрч, холбогдох мэдээллийг нийтлэх боломжоор хангах;

5.2.9.цахим системээр зохион байгуулж буй тендер шалгаруулалт, түүнд нийтлэгдэж буй мэдээлэлд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, хяналт тавих, гарсан зөрчлийг арилгуулах тухай холбогдох байгууллагуудад шаардлага, мэдээлэл, зөвлөгөө хүргүүлэх;

5.2.10.захиалагч, аж ахуй эрхлэгч цахим системийн үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөөгүй бол мэргэжлийн байгууллага үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй;

5.2.11.Цахим системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагаа, сургалт, сурталчилгаа, нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллахтай холбогдуулан мэргэжлийн байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран цаг үеийн асуудлаар улирал тутам уулзалтыг зохион байгуулах;

5.2.12.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гомдол хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага, хууль, хяналтын байгууллагыг холбогдох үйл ажиллагааны хүрээнд хяналт тавих боломжоор хангах, цахим системд нэвтрэх эрхийг олгох.

#### Зургаа.Аж ахуй эрхлэгчийн эрх, үүрэг

6.1.Аж ахуй эрхлэгч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 35.2-т заасан үүргийг хүлээнэ.

6.2.Аж ахуй эрхлэгч цахим системд нэвтрэх эрх авсан ажилтны үйлдэл, эс үйлдэл, түүнд олгогдсон эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүх хариуцлагыг хүлээнэ.

6.3.Аж ахуй эрхлэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарах аливаа хариуцлагыг оролцогч өөрөө хариуцна.

6.4.Аж ахуй эрхлэгч, түүнийг төлөөлөн цахим системд нэвтрэх эрх бүхий этгээд цахим системд нэвтрэх эрх, нууц үгийн нууцлалыг чандлан хадгалах ба нууцлалыг алдсан, мартсан тохиолдолд цахим системээр мэргэжлийн байгууллагад хүсэлт гаргаж, бүртгэлтэй цахим шуудангаар хариуг хүлээж авна.

6.5.Оролцогч холбогдох цахим системээс дамжуулан авч буй өөрийн тендерт холбоотой мэдээлэл, өөрийн ирүүлсэн тендер, түүнд хавсаргасан аливаа баримт бичгийн үнэн зөв эсэхийг нягтлах, алдаатай тохиолдолд тендер хүлээж авах эцсийн хугацаанаас өмнө залруулах үүрэгтэй ба энэ үүргээ биелүүлээгүйтэй холбоотой хариуцлагыг дангаар хүлээнэ.

6.6. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэх үүрэгтэй.

6.7. Оролцогч байгуулсан гэрээний гүйцэтгэлийн талаарх мэдээллийг нотлох баримтын хамт бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн хуваарийн дагуу цахим системд бүртгэнэ.

6.8. Энэ журмын 2.2.8-д заасны дагуу шалгарсан оролцогчийн тендерийн нууцлаагүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулгатай танилцах бусад оролцогч нь нууц хадгалах тухай баталгааг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргана.

#### Долоо. Захиалагчийн эрх, үүрэг

7.1. Захиалагч худалдан авах ажиллагааг энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу цахим системээр зохион байгуулна.

7.2. Захиалагч хуулийн 48.4.9-д зааснаас бусад баримт бичгийг тендер шалгаруулалт зохион байгуулж дууссанаар, хуулийн 48.4.9-д заасан баримт бичгийг гэрээг дүгнэж бараа, ажил, үйлчилгээг хүлээн авснаар зохих журмын дагуу архивлан хадгална.

7.3. Хуулийн 48.4-т заасан тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хамаарах баримт бичгээс цахим хэлбэрээр үйлдсэн баримт бичгийг цахим хэлбэрээр тусгай тээгч (зөөврийн хатуу диск, оптик диск) дээр архивлан хадгална.

7.4. Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч гэрээ байгуулсан өдөрт багтаан цахим системд байршуулна.

7.5. Энэ журмын 7.4-т зааснаар байршуулсан гэрээг шүүх хүчин төгөлдөр бус гэж тогтоосон, эсхүл гэрээ цуцлагдсан, гэрээнээс татгалзсан бол захиалагч холбогдох мэдээллийг тухай бүр цахим системд шинэчилнэ.

7.6. Захиалагч энэ журмын 7.4-т заасан гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг цахим системд хөтөлнө.

7.7. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлтэй танилцах оролцогч цахим системээр хүсэлт гаргах ба хуулийн 28.1-д заасан шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн хугацаанд оролцогчид танилцуулна.

7.8. Цахим системээр зохион байгуулаагүй тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчийн тендерийн нууцлаагүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулга, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлтэй танилцах бусад оролцогч нь бичгээр захиалагчид хүсэлт гаргаж, нууц хадгалах тухай баталгааг бичгээр гаргана. Захиалагч хүсэлтийн дагуу хуулбар хувийг танилцуулж, холбогдох баримт бичигтэй танилцсан оролцогчийн тухай тэмдэглэл үйлдэж, гарын үсгээр баталгаажуулан тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хадгална.

7.9. Захиалагч үнэлгээний хороонд ажиллах захиалагчийн ажилтан, албан тушаалтыг холбогдох сургалтад тогтвортой хамруулах үүрэгтэй.



7.10.Цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээний нэг удаагийн захиалгын хуудаст тусгагдсан худалдан авалтын хэмжээ тухайн төсвийн жилд цахим дэлгүүрээс худалдан авах нийт бараа, үйлчилгээний төсвийн 50 хувиас хэтрэхгүй байхаар төлөвлөгөөнд тусгана.

7.11.Тухайн төсвийн жилд цахим дэлгүүрээс нэг бараа, үйлчилгээг нэг удаа худалдан авахаар төлөвлөсөн бол энэ журмын 7.10-д заасныг баримтлахгүй.

#### Найм.Цахим системийн аюулгүй ажиллагаа

8.1.Цахим системийн үйл ажиллагаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

8.2.Мэргэжлийн байгууллага цахим систем, түүний аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг хангуулах дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.2.1.цахим систем нь төрөөс баримтлах харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэл, мэдээллийн аюулгүй байдлын стандартад нийцсэн байх;

8.2.2.цахим системийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор цахим системд байнгын хяналт тавих;

8.2.3.худалдан авах ажиллагааны хууль, журамд нийцүүлэн цахим системийн үйл ажиллагааны шинэчлэл, сайжруулалтыг тасралтгүй хийх;

8.2.4.цахим системд жил бүр аудит хийлгэх;

8.2.5.цахим системийн аюулгүй байдал, нууцлалыг хангах, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд хуулийн 49.4.7-д заасан хураамжаас зарцуулах;

8.2.6.цахим системийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг ханган ажиллахдаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр танилцуулж, холбогдох саналыг хэрэгжүүлж ажиллах;

8.3.Энэ журмын 8.2.4-т заасан цахим системд аудит хийлгэх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

8.4.Мэргэжлийн байгууллага цахим системийн ашиглалт, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дотоод журмыг баталж, хэрэгжүүлж болно.

#### Ес.Бусад зүйл

9.1.Хуульд заасан гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага цахим системээр зохион байгуулсан тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээллийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д зааснаар цахим системээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

9.2.Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас цахим систем ажиллах боломжгүйгээс шалтгаалан сонирхогч этгээд тендер шалгаруулалтад оролцох боломжгүй болсноос үүдэн гарах аливаа хариуцлагыг

төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн байгууллага болон захиалагч хариуцахгүй.

9.3.Энэ журмын 9.2-д зааснаар цахим систем ажиллах боломжгүй болсон тохиолдолд мэргэжлийн байгууллага энэ тухай захиалагчид нэн даруй мэдэгдэж, тендерийн нээлтийг тодорхой хугацаагаар хойшлуулж, энэ тухай цахим системээр дамжуулан, боломжгүй бол харилцаа холбооны бусад хэрэгслээр нэгэн зэрэг мэдэгдэнэ.

9.4.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---